



ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 03 сарын 11 өдөр

Дугаар А/126

Хэрлэн сум

Журам шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсгийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан зорилго, зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг хангах, мэдээ мэдээллийг шуурхай солилцох, байгууллага хоорондын ажлын уялдаа холбоог сайжруулах, аймгийн удирдлагаас өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг хангуулах, удирдах албан тушаалтны хариуцлагыг сайжруулах зорилгоор "Хэнтий аймгийн удирдах ажилтны хуралдааны тов, дэгийг тогтоох журмыг хавсралтаар баталсугай.

2. Энэхүү журмыг 2025 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс мөрдлөг болгон ажилласугай.

3. Хэнтий аймгийн удирдах ажилтны хуралдааны тов, дэгийг тогтоох журмын биелэлтэд хяналт тавьж, хэрэгжилтийг зохион байгуулж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (А.Жаргалсайхан)-д үүрэг болгосугай.

4. Энэ захирамж гарч байгаатай холбогдуулан 2016 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн А/500, 2021 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн А/89 дугаар захирамжийг хүчингүй болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Д.АЮУРБУНЬ





5/2/20

فصل در تفسیر و تفسیر و تفسیر

[illegible]

حسن محمد حسن... محمد... محمد...

УДИРДАХ АЖИЛТНЫ ХУРАЛДААНЫ ТОВ, ДЭГ ТОГТООХ ЖУРАМ

Нэг. Зорилго

1.1 Энэхүү журмын зорилго нь (цаашид Хуралдаан гэх) Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан зорилго, зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг хангах, мэдээ мэдээллийг шуурхай солилцох, байгууллага хоорондын ажлын уялдаа холбоог сайжруулах, аймгийн удирдлагаас өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг хангахад оршино.

Хоёр. Хуралдаанаар хэлэлцэх асуудал

2.1 Хуралдааны бэлтгэл ажлыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтэс хариуцан зохион байгуулна

2.2 Тухайн өдрийн хуралдаанаар оролцогч байгууллагуудын үйл ажиллагааны талаарх мэдээлэл, өмнөх хуралдаанаас өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилт, үр дүн, цаг үеийн тулгамдаж байгаа асуудлууд, түүнийг хэрхэн шийдвэрлэх талаар мэргэжлийн байгууллагуудын саналыг сонсох, шинээр болон төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг хэрэгжүүлэх талаар холбогдох албан тушаалтнуудад үүрэг даалгавар өгч биелэлтийг хангах асуудлыг хэлэлцэнэ.

2.3 Аль нэг салбарт хамааралтай асуудлаар зөвлөлдөх шаардлага гарвал зөвхөн тухайн салбарын удирдлагууд болон холбогдох албан тушаалтнуудад, Удирдлагын зөвлөлийн гишүүдийг оролцуулан аймгийн Засаг дарга шуурхай зөвлөгөөн зарлаж болно

2.4 Аймгийн Засаг даргын Удирдлагын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцсэн асуудал болон гарсан шийдвэрийн тухай хэлэлцэж болно.

Гурав. Хуралдааны дэг

3.1 Хуралдаанаар аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан зорилго, зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээний хэрэгжилт, аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, байгууллагын дарга нарт өгсөн үүрэг чиглэлийн хэрэгжилт, цаг үеийн тулгамдаж байгаа асуудлуудыг тус тус хэлэлцэнэ.

3.2. Хуралдааныг “Агентлаг, байгууллагын дарга нарын өргөтгөсөн хуралдаан”, “Агентлагийн дарга нарын шуурхай хуралдаан”, “Аймаг, сумдын удирдлагуудын цахим хуралдаан”, “Бүтээн байгуулалтын зөвлөлийн хуралдаан”, “Аймгийн Засаг даргын удирдлагын зөвлөлийн хурал” гэх 5 төрлөөр сар бүр тогтоосон хугацаанд зохион байгуулж, тухайн хуралдаанд оролцох.

3.3.Хуралдаанд доорх албан тушаалтан хамрагдана:

- Агентлаг, байгууллагын дарга нарын өргөтгөсөн хуралдаанд: Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, бусад төрийн байгууллагын удирдлага, сургууль цэцэрлэгийн Захирал, эрхлэгч нар

-Агентлагийн дарга нарын шуурхай хуралдаанд: Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлагийн удирдлагууд

- Аймаг, сумдын удирдлагуудын цахим хуралдаанд: Аймгийн удирдлагууд болон Сумын Засаг дарга, сумын Засаг даргын орлогч, Засаг даргын Тамгын газрын дарга, Хот тосгоны Захирагч, Захирагчийн орлогч, Захирагчийн ажлын албаны дарга нар /цахимаар/

- Бүтээн байгуулалтын зөвлөлийн хуралдаанд: Аймгийн Засаг даргын орлогч, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга, Хэрлэн сумын Засаг дарга бөгөөд Чингис хотын захирагч, Хууль, эрх зүйн хэлтсийн дарга, Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга, Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Дарга, Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга Барилга, хот байгуулалтын хэлтсийн дарга, Аймгийн ерөнхий архитектор, Худалдан авах ажиллагааны газрын дарга, Орон нутгийн өмчийн газрын дарга, Хэнтий цахилгаан түгээх сүлжээ салбарын Захирал, "Харгуй" ТӨХК -ийн гүйцэтгэх захирал, "Хэнтий-Ус" ХХК-ийн гүйцэтгэх захирал, Мэдээлэл холбооны сүлжээ ТӨК-ий Хэнтий аймаг дахь газрын ерөнхий инженер.

-Аймгийн Засаг даргын удирдлагын зөвлөлийн хуралд: аймгийн Засаг дарга, аймгийн Засаг даргын орлогч, аймгийн Засаг даргын орон тооны зөвлөх, аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга, аймгийн Засаг даргын Тамгын газрын хэлтсийн дарга нар

3.4 Хуралдааныг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга удирдан явуулна. Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын эзгүйд Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга удирдан явуулна.

3.5 Хуралдаанд танилцуулах мэдээллийг тухайн байгууллагын удирдлага өөрийн биеэр танилцуулна.

3.6 "Агентлагийн дарга нарын шуурхай хуралдаан", "Агентлаг, байгууллагын дарга нарын өргөтгөсөн хуралдаан"-ны ирц, хэлэлцсэн асуудал, үүрэг даалгаврын тэмдэглэлийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн Хүний нөөц, агентлаг хариуцсан мэргэжилтэн, "Сумдын удирдлагуудын хуралдаан"-ны ирц, хэлэлцсэн асуудал, үүрэг даалгаврын тэмдэглэлийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн орон нутаг

хариуцсан мэргэжилтэн, тус тус хөтөлж, үүрэг даалгаврын биелэлтэд харьяа хэлтсийн дарга нар хяналт тавина.

3.7 АЗДТГ-ын хэлтсүүд харьяа агентлаг, байгууллагуудтай хийсэн хуралдааны тэмдэглэлийг тухайн хэлтсийн холбогдох мэргэжилтэн хөтөлж хэлэлцсэн асуудал үр дүнгийн талаарх танилцуулгыг удирдлагын зөвлөлийн хуралд хэлтсийн дарга нар тухай бүр танилцуулна.

3.8 Шаардлагатай тохиолдолд журмын хавсралтаар баталсан хуваарьт тусгагдаагүй үед аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсээс танхимаар болон цахимаар хуралдаан зарлаж болно.

Дөрөв. Хуралдаанд мэдээлэл хийх, мэдээлэлд тавигдах шаардлага

4.1 Агентлаг, байгууллагын дарга нарын өргөтгөсөн хуралдаан, агентлагийн дарга нарын шуурхай хуралдаан болон аймаг, сумдын удирдлагуудын цахим хуралдаанд мэдээлэл хийх агентлаг, байгууллага, хэлтсүүд тус бүр 10 минутад багтаан холбогдох мэдээллийг хүргэнэ. Мэдээллийг хуралдаан болохоос 1 хоногийн өмнө Төрийн захиргааны удирдлагын хэлтэст ирүүлсэн байна.

4.2. Хуралдаанд хийх мэдээлэл дараах шаардлагыг хангасан байна

4.2.1. Мэдээлэл товч тодорхой ойлгомжтой цэгцтэй байх

4.2.2. Харьцуулсан тоо мэдээ, тооцоо судалгаатай байх

4.2.3. Төсөв санхүүгийн эх үүсвэрээ тодорхойлсон байх

4.2.4. Хууль тогтоомжийн хүрээнд байх

4.2.5. Фото зураг болон дүрс бичлэгээр баримтжуулсан байх

4.3. Агентлаг, байгууллагын дарга нарын өргөтгөсөн хуралдаан болон агентлагийн дарга нарын шуурхай хуралдаанд дараах байгууллагууд тогтмол мэдээлэл танилцуулна.

4.3.1. Хэрлэн сум

4.3.2. Онцгой байдлын газар

4.3.3. Эрүүл мэндийн газар

4.3.4. Ус цаг, уур орчны шинжилгээний төв

4.3.5. Цагдаагийн газар

Тав. Хуралдаанд оролцогчдын хүлээх үүрэг, хариуцлага

5.1 Хуралдаанд оролцогч удирдах албан тушаалтан нь хуралдаан дээр өгөгдсөн үүрэг даалгавар, мэдээ мэдээллийг өөрийн байгууллагын хамт олонд мэдээлж, ажил хариуцан гүйцэтгэх албан тушаалтнуудад үүрэг чиглэл өгч биелэлтийг хангуулна

5.2 Хуралдаанд агентлагийн дарга нар ээлжийн амралттай, өвчтэй, чөлөөтэй, томилолттойгоос бусад тохиолдолд заавал өөрийн биеэр оролцоно.

5.3 Хуралдааныг тасалсан, өгсөн үүрэг даалгаврыг хугацаанд нь биелүүлээгүй болон огт биелүүлээгүй төрийн албан хаагчдад Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хуульд болон бусад хууль тогтоомжийн хүрээнд хариуцлага ногдуулна.

5.4 Хуралдаанд оролцогч албан тушаалтан нь хуралдаанаар өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг аймгийн Засаг даргын өмнө биечлэн хариуцна

5.5 Хуралдаанд зөвхөн нийтийг хамарсан асуудлаар санал тавьж, асуудал дэвшүүлнэ

5.6 Хуралдаанд оролцох албан тушаалтан нь энэ журмын 5.2-т заасныг мэдэгдээгүй тохиолдолд орлон ирсэн албан тушаалтныг тухайн хуралдаанд оролцуулахгүй

Зургаа. Хурлын тов, хуваарь

Д/д	Арга хэмжээ	Хугацаа	Хаана	Хариуцах хэлтэс
1	Агентлаг, байгууллагын дарга нарын өргөтгөсөн хуралдаан	Сар бүрийн 2 дахь долоо хоногийн Мягмар гарагийн 14:00 цагт	Аймгийн Засаг даргын Тамгын газрын иргэний танхим	ТЗУХ
2	Агентлагийн дарга нарын шуурхай хуралдаан	Сар бүрийн 4 дэх долоо хоногийн Мягмар гарагийн 14:00 цагт	Аймгийн Засаг даргын Тамгын газрын иргэний танхим	
3	Аймаг, сумдын удирдлагуудын цахим хуралдаан	Сар бүрийн 2 дахь долоо хоногийн Лхагва гарагийн 14:00 цагт	Цахим /zoom/	
	Аймгийн Засаг даргын удирдлагын зөвлөлийн хурал	7 хоног бүрийн даваа гарагийн 08:30 цагт	Аймгийн Засаг даргын Тамгын газрын 218 тоот өрөө	
4	Бүтээн байгуулалтын зөвлөлийн хуралдаан	Тухай бүр	Аймгийн Засаг даргын Тамгын газрын зөвлөлийн өрөө	ХБТХОХ